



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/788

Арвайхээр

Бэлэн байдал хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны 01 дүгээр сараас эхлэн ихэнх нутгаар их хэмжээний цас орж, хүйтний эрч чангарах төлөвтэй байгаа тул бүх сумдын Засаг дарга, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга нар хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосугай.

1.1. Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийн талаар урьдчилан сэргийлэх мэдээг шуурхай цаг алдалгүй гаргаж аймгийн Онцгой комисс болон холбогдох алба, мэргэжлийн ангид мэдээлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Ус, цаг уур, орчны шинжилгээний газар (Б.Оюунчимэг)-т,

1.2. Эрчим хүчний салбарт учирч болох эрсдэлийг урьдчилан тооцоолж яаралтай засвар үйлчилгээ хийх, осол гэмтэл гарсан тохиолдолд засварлах машин, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг ЭБЦТС ТӨХК (Б.Дэмбэрэлсайхан)-т,

1.3. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллийг Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор баталсан "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-ын 3.1-д заасны дагуу дамжуулж шаардлагатай үед Онцгой комиссын хурлын бэлтгэл ажлыг ханган хуралдуулж шийдвэр гаргуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Эрдэнэбат)-т,

1.4. Гэр орон сууц, хашаа, барилга, байгууламж нурж эвдрэх, гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас хүн, мал төөрч сураггүй болсон тохиолдолд яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай хүн хүч, туулах чадвар сайтай автомашин, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт,

1.5. Болзошгүй цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийн үед шаардагдах эм тарианы нөөцийг бүрдүүлж, багаж тоног төхөөрөмж, автомашин, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т,

1.6. Төвлөрсөн худаг, усан хангамжийн найдвартай доголдолгүй ажиллагааг хангаж гарсан эвдрэл гэмтлийн богино хугацаанд шуурхай засварлах хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн "Онги ус суваг"-ийн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (О.Лхагвасүрэн)-т,

1.7. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийн дагуу цаг агаарын нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж хот хооронд болон орон нутгийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдын аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг аймгийн Авто тээврийн төв (З.Балданням)-д,

011101722

1.8. Цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдэл, техникийн саатлын үед Улсын онц чухал болон дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллага, объектуудын шаардлагатай үед ажиллуулах цахилгааны нөөц үүсгүүрийн бэлэн байдлыг хангаж ямар нэг доголдол гаргалгүй ажиллах нөхцөлийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нар болон аж ахуйн нэгжийн дарга, удирдлагад үүрэг болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД